



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/53

Халбан

**Газар ашиглах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүрхээр багт нүүрс олборлох зориулалттай "Могойн гол" ХК (2034859), 6732001338 нэгж талбарын дугаартай 897819 га газар ашиглах хугацааг 15 жилээр сунгаж ашиглуулсугай.

2.Газар ашиглагч "Могойн гол" ХК-ий нүүрсний уурхайн гүйцэтгэх захирал Ө.Хүчитбаатартай газар ашиглах гэрээ байгуулан гэрчилгээ олгохыг Газрын даамал (Н.Цасанчихэр)-т даалгасугай.

3.Газрын тухай хуулиуд, Ашигт малтмалын тухай хуулиуд, гэрээнд заасан нөхцөл шаардлагыг биелүүлэн ашиглахыг газар ашиглагч "Могойн гол" ХК-ийн гүйцэтгэх захирал (Ө.Хүчитбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

